



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН “БАТШИРЭЭТ”
СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 5/23

Батширээт сум

[Баттулга овогтой Дуламжавыг ажлаас чөлөөлж,
ахлах техникчийн ажилд томилох тухай]

Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль”-ийн 67 дугаар зүйлийн 67.4 дэх заалт, “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалт, 49 дүгээр зүйлийн 49.1 дэх заалт, 78 дугаар зүйлийн 78.1.1 дэх заалт, Монгол улсын Засгийн газрын 2023 оны 06 дугаар 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолын 10 дугаар хавсралт, Монгол улсын засгийн газрын 84 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт, “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 238 дугаар тогтоол, Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ойн газрын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01/17 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ахлах техникч Баттулга овогтой Дуламжавыг 2025 оны 07-р сарын 04-ний өдрөөс эхлэн түр орон тооны ахлах техникчийн үүрэгт ажлаас чөлөөлж, Ахлах техникчийн ажилд томилсугай.

2. Ахлах техникч Баттулга овогтой Дуламжавын цалинг ТҮ- 7 шатлал буюу 1,340,000 (нэг сая гурван зуун дөчин мянга) төгрөгөөр тооцож цалинг олгохыг нягтлан бодогч (Д. Мөнхтүвшин)-д зөвшөөрсүгэй.



• 242501023